МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 04 өдөр Дугаар А/266 Улаанбаатар хот

Мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, гишүүд, зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын бодлого тодорхойлох, эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангахад дэмжпэг үзүүлэх, мэргэжпийн чиглэлээр зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус Эрүүл мэнд, спортын яамны мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга, гишүүдийн нэрсийг нэгдүгээр, мэргэжпийн салбар зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ерөнхий мэргэжилтэн, түүний удирдлага дор ажиллах мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, хагас, бүтэн жилээр үнэлгээ өгч ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/ -т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 150, 219 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД С.ЛАМБАА

080952

Эрүүл мэнд, спортын сайдын
2016...оны 07...сарын 04-өдрийн
А/266...тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНД СПОРТЫН ЯАМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН, ГИШҮҮДИЙН НЭРС

№	Нэрс	Албан тушаал		Зэрэг, цол
1. Мэс заслын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Л.Амгалан	Ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, Клиникийн профессор
2	П.Мөнхтуул	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн Хүний нөөц, хөгжлийн албаны дарга	Ахлах зэргийн эмч
3	О.Сэргэлэн	Гишүүн	АШУҮИС-ийн мэс заслын тэнхмийн эрхлэгч	Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
4	С.Эрдэнэ	Гишүүн	АШУҮИС-ийн Мэс заслын тэнхмийн багш	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
5	Ц.Ишдорж	Гишүүн	УНТЭ-ийн мэс заслын эмч	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
6	М.Түмэннасан	Гишүүн	Монголын мэс заслын нийгэмлэгийн тэргүүлэгч,	Анагаах Ухааны доктор, профессор
7	М.Ганбаатар	Гишүүн	УГТЭ-ийн ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
8	Ц.Нармандах	Гишүүн	УХТЭ-ийн мэс заслын зөвлөх эмч	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
9	Д.Батболд	Гишүүн	"Мишээл" эмнэлгийн мэс заслын эмч	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
10	Х.Бат-Орших	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
11	Н.Ганбат	Гишүүн	УНТЭ-ийн мэс заслын эмч	Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч
2. Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	О.Оюунбилэг	Ерөнхий мэргэжилтэн	ШАУДС-ийн тэнхмийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Л.Мөнхтуяа	Нарийн бичгийн дарга	Яаралтай тусламжийн хөгжлийн нийгэмлэгийн нарийн бичгийн дарга	Анагаах ухааны магистр
3	З.Лхагвасүрэн	Гишүүн	УГТЭ-ийн ангиографийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, клиникийн профессор
4	Р.Энхсайхан	Гишүүн	ГССҮТ-ийн их эмч	Анагаах ухааны доктор
5	М.Алтанхуяг	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч	Анагаах ухааны магистр

6	С.Алтансүх	Гишүүн	УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
7	А.Оюунчимэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албаны дарга	Анагаах ухааны магистр
8	Ө.Билгүүн	Гишүүн	АШУҮИС-ийн Яаралтай тусламж, мэдээгүйжүүлгийн тэнхмийн багш	Анагаах ухааны магистр, докторант
9	Б.Батсүх	Гишүүн	ХӨСҮТ-ийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
10	М.Цэнгэлмаа	Гишүүн	БХХСАХНЭ-ийн Хордлогын төвийн эмч	Анагаах ухааны магистр
11	Д.Санжаа	Гишүүн	УХТЭ-ийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, Клиникийн профессор
3. Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Д.Уранчимэг	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС, профессорын багийн ахлагч	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Ц.Мөнхзаяа	Нарийн бичгийн дарга	"Инфинити" эмнэлгийн ерөнхий эмч	Анагаах ухааны докторант
3	Ж.Баасанхүү	Гишүүн	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор, профессор
4	Т.Булган	Гишүүн	АШУҮИС-ийн багш, Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн тэргүүн	Анагаах ухааны доктор, дэд профессор
5	Д.Лхагвадолгор	Гишүүн	УНТЭ-ийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор
6	Ч.Цэнгэлмаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Нүдний тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
7	П.Бүрэнжаргал	Гишүүн	УНТЭ-ийн Нүдний тасгийн эрхлэгч	Клиникийн профессор
8	Ж.Баттуяа	Гишүүн	УГТЭ-ийн Нүдний тасгийн эрхлэгч	Клиникийн профессор
9	Б.Цэцэгжаргал	Гишүүн	"Болор мэлмий" эмнэлгийн Ерөнхий эмч	Анагаах ухааны магистр
4. Хүүхдийн анагаахын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Г.Эрдэнэтуяа	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхмийн ахлах багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Б.Баясгалантай	Нарийн бичгийн дарга	АХБ-ны төслийн дотоодын зөвлөх	Анагаах ухааны доктор
3	Д.Малчинхүү	Гишүүн	АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор, профессор
4	Ж.Адьъяасүрэн	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн клиникийн Ерөнхийн мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
5	Р.Отгонбаяр	Гишүүн	АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
6	З.Гэрэлмаа	Гишүүн	АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхмийн ахлах багш	Анагаах ухааны доктор, дэд профессор

7	Д Навчаа	Гишүүн	Хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлгийн их эмч	Анагаах ухааны доктор
8	А.Золжаргал	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн клиникийн Чих, хамар хоолойн тасгийн их эмч	Анагаах ухааны магистр
9	Г.Отгонсүрэн	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн клиникийн Хоол боловсруулах эмгэг судлалын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
10	Т.Болормаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
11	П.Отгонбаяр	Гишүүн	Бүүвэй ээж эмнэлгийн хүүхдийн мэдрэлийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор, клиникийн профессор
5. Эрчимт эмчилгээ, амь тэнссэн үеийн анагаахын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Л.Ганболд	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Г.Отгонтуяа	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	Анагаах ухааны докторант
3	Х.Урангоо	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эх барихын клиникийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
4	А.Эрдэнэдалай	Гишүүн	УГТЭ-ийн мэдээгүйжүүлэгийн тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
5	Р.Баянмөнх	Гишүүн	БХХСАХНЭ-ийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
6	Х.Баялагмаа	Гишүүн	УНТЭ-ийн мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
7	М.Ариунтунгалаг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн мэс заслын клиникийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
8	Л.Оюунтунгалаг	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасгийн их эмч	Анагаах ухааны магистр
9	Д. Ариунболд	Гишүүн	Нийслэлийн яаралтай тусламжийн төвийн дэд дарга	Анагаах ухааны магистр
6. Дүрс оношилгоо, радиологийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	З.Лхагвасүрэн	Ерөнхий мэргэжилтэн	УГТЭ-ийн ангиографийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, Клиникийн профессор
2	Ц.Эрдэмбилэг	Нарийн бичгийн дарга	Интермед эмнэлгийн дүрс оношилгооны эмч	Анагаах ухааны доктор
3	Ц.Бадамсэд	Гишүүн	УГТЭ-ийн радиологийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор, профессор

4	Р.Асай	Гишүүн	ХСҮТ-ийн радиологийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор, клиникийн профессор
5	В.И.Маслов	Гишүүн	УНТЭ-ийн дурангийн зөвлөх эмч	Клиникийн профессор
6	Б.Эрдэнэбулган	Гишүүн	ХСҮТ-ийн эмч дүрс оношилгооны эмч	Анагаах ухааны доктор
7	З.Хишигжаргал	Гишүүн	УНТЭ-ийн радиологийн зөвлөх эмч	Клиникийн профессор
8	П.Баясгалан	Гишүүн	ХӨСҮТ-ийн онош зүйн тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
9	Д.Түвшинжаргал	Гишүүн	УБ, Сонгдо эмнэлгийн дүрс оношилгооны тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
7. Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	Н.Мөнхтүвшин	Ерөнхий мэргэжилтэн	Анагаах ухааны хүрээлэнгийн нэгдсэн лабораторийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, профессор
2	М.Ариунаа	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор
3	Б.Дармаа	Гишүүн	ХӨСҮТ-ийн Вирүс судлалын лабораторийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
4	С.Цогтсайхан	Гишүүн	АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	Анагаах ухааны доктор, профессор
5	Г.Наран	Гишүүн	УГТЭ-ийн лабораторийн их эмч	Анагаах ухааны доктор
6	Ц.Энхжаргал	Гишүүн	НЭМХ-ийн лабораторийн эрхлэгч	Биологийн ухааны доктор
7	Н.Энхжаргал	Гишүүн	ХСҮТ-ийн МБЛ-ийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
8	Д.Алтанцэцэг	Гишүүн	ХӨСҮТ-ийн их эмч	Анагаах ухааны доктор
9	Ж.Саранцэцэг	Гишүүн	УНТЭ-ийн лабораторийн эмч	Анагаах ухааны доктор
10	Н.Батнасан	Гишүүн	МЭМЛАХ-ын УЗ-ийн гишүүн	Анагаах ухааны магистр
11	С.Чимэдцэрэн	Гишүүн	УНТЭ-ийн лабораторийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
8. Харшил судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	С.Мөнхбаярлах	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Анагаахын сургуулийн захирал	Анагаах ухааны доктор, профессор
2	Л.Наранцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн багш	Биологийн ухааны доктор
3	Н.Раднааханд	Гишүүн	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор, профессор
4	Л.Баттөр	Гишүүн	УНТЭ-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал	Анагаах ухааны доктор, дэд профессор
5	Ж.Соёл-Эрдэнэ	Гишүүн	Төмөр замын нэгдсэн эмнэлгийн чанарын менежер	Анагаах ухааны доктор
6	Б.Энхбаяр	Гишүүн	"Ач" АУИС-ийн багш	Анагаах ухааны магистр

7	Т.Рэгзэдмаа	Гишүүн	УНТЭ-ийн харшлын эмч	Анагаах ухааны магистр, зөвлөх зэргийн эмч
9. Дотрын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Н.Бира	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн хоол боловсруулах эрхтэн судлалын профессорын багийн багш	Анагаах ухааны доктор, дэд пр0, офессор
2	Д.Даваадорж	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн дэд захирал	Анагаах ухааны доктор, профессор
3	С.Наранцэцэг	Гишүүн	УГТЭ-ийн эмчилгээ эрхэлсэн захирал	Анагаах ухааны доктор
4	С.Өлзийсайхан	Гишүүн	УНТЭ-ийн Уушиг судлалын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, Клиникийн профессор
5	Д.Зулгэрэл	Гишүүн	АШУҮИС-ийн зүрх судас, ревматологийн профессорын багийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
6	Баясгалан	Гишүүн	АШУҮИС-ийн дотоод шүүрэл судлалын профессорын багийн ахлагч	Анагаах ухааны доктор
7	Т.Ариунаа	Гишүүн	АШУҮИС-ийн бөөр судлалын профессорын багийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
8	О.Баярмаа	Гишүүн	УНТЭ-ийн их эмч	Анагаах ухааны докторант
9	Н.Мөнгөн-Өлзий	Гишүүн	УГТЭ-ийн их эмч	Анагаах ухааны магистр
10. Уламжлалт анагаахын мэргэжлийн салбар зөвлөл				
1	З.Мэндсайхан	Ерөнхий мэргэжилтэн	Монголын хувийн эмнэлгүүдийн холбооны захирал	Анагаах ухааны доктор
2	Г.Одонцэцэг	Нарийн бичгийн дарга	Оточ Манрамба их сургуулийн дэд захирал	Анагаах ухааны доктор
3	Д.Цэрэндавга	Гишүүн	АШУҮИС-ийн УАУ-ны институтийн захирал	Академич, доктор, профессор
4	Д.Нацагдорж	Гишүүн	Монголын уламжлалт эмнэлэг, сургалтын төвийн захирал	Анагаах ухааны доктор
5	Ж.Амарсанаа	Гишүүн	Ази, номхон далайн Элэгний эмгэг судлалын холбооны зөвлөх	Анагаах ухааны доктор
6	Ж.Батнайрамдал	Гишүүн	АШУҮИС-ийн УАУ-ны институтийн багш	Анагаах ухааны доктор
7	Ш.Болд	Гишүүн	Монос эмзүйн их сургуулийн УАУ-ны сургуулийн захирал	Академич, доктор, профессор
8	Ч.Чимэдрагчаа	Гишүүн	УАШУТҮК-ий захирал	Анагаах ухааны доктор, профессор
9	Г.Машбат	Гишүүн	"Ачуут гол" эмнэлгийн захирал	Анагаах ухааны доктор

10	М.Амбага	Гишүүн	Шинэ анагаах ухааны дээд сургуулийн захирал	Анагаах ухааны доктор, профессор
11	Ж.Тогтохбаяр	Гишүүн	МХЕГ-ын мэргэжилтэн	Анагаах ухааны докторант
11. Халдварт өвчин, нян судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	О.Баатархүү	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Халдвартын тэнхимийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Б.Буянхишиг	Нарийн бичгийн дарга	ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн лабораторийн зөвлөх	Анагаах ухааны доктор
3	П.Нямдаваа	Гишүүн	ХӨСҮТ-ийн зөвлөх	Академич,Анагаахын шинжпэхухааныдоктор, профессор
4	М.Алтанхүү	Гишүүн	Монголын Вирүс судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	Анагаах ухааны доктор
5	Д.Алтанцэцэг	Гишүүн	ХӨСҮТ-ийн Нян судлалын лабораторийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
6	Д.Даваалхам	Гишүүн	АШУҮИС-ийн Эпидемиологи-биостатистикийн тэнхмийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, дэд профессор
7	Ундармаа	Гишүүн	ХӨСҮТ-ийн их эмч	Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
8	Д.Наранзул	Гишүүн	ХӨСҮТ-ийн Сүрьеэтэй тэмцэх албаны судалгааны зохицуулагч	Анагаах ухааны доктор
9	Р.Оюунгэрэл	Гишүүн	АШУҮИС-ийн Халдвартын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
10	Т.Хосбаяр	Гишүүн	АШУҮИС-ийн Биохими, эсийн биологийн тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
11	Н.Цэнд	Гишүүн	ХӨСҮТ-ийн зөвлөх	Анагаах ухааны доктор
12. Уролог, андролог мэргэжлийн салбар зөвлөл				
1	Д.Нямсүрэн	Ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн бөөрний мэс заслын зөвлөх	Анагаах ухааны доктор, профессор
2	Г. Ганболд	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн их эмч	Анагаах ухааны доктор
3	Д. Баян-Өндөр	Гишүүн	УНТЭ-ийн Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
4	Б. Энхравдан	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн урологийн тасгийн эрхлэгч	Монгол улсын Хүний гавьяат эмч
5	М. Мөнхжаргал	Гишүүн	"СОНГДО" эмнэлгийн эмч	Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
6	Н. Саранцэцэг	Гишүүн	УНТЭ-ийн Бөөрний мэс заслын тасгийн их эмч	Ахлах зэргийн эмч
7	М.Эрдэнэсайхан	Гишүүн	УНТЭ-ийн Бөөрний мэс заслын тасгийн их эмч	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч

13. Гэмтэл согог судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	С.Баатаржав	Ерөнхий мэргэжилтэн	ГССҮТ-ийн Эрдэм шинжилгээ сургалт хариуцсан дэд захирал	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	А.Эрдэнэбилэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Гэмтэл согог судлалын тэнхмийн эрхлэгч	Клиникийн профессор
3	Р.Шагдарсүрэн	Гишүүн	ГССҮТ-ийн зөвлөх	Анагаахын шинжлэх ухааныдоктор
4	Ц.Ганзоригт	Гишүүн	ГССҮТ-ийн Тархи нуруу нугасны тасгийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор, Клиникийн профессор
5	Т.Баянхүү	Гишүүн	"Ортопед" эмнэлгийн захирал	АУ-ны доктор, Клиникийн профессор
6	Отгонбаяр	Гишүүн	УНТЭ-ийн мэс заслын тасгийн их эмч	Анагаах ухааны доктор
7	Т.Сүхбаатар	Гишүүн	БХХСАХНЭ-ийн Гэмтлийн тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
8	Ө.Өлзийбаатар	Гишүүн	ГССҮТ-ийн Насанд хүрэгчдийн гэмтэл согогийн тасгийн эрхлэгч	АШУ-ны магистр, Клиникийн профессор
9	Ц.Оюунбаяр	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн Гэмтлийн мэс заслын тасгийн их эмч	Анагаах ухааны магистр
10	С.Төгсбаяр	Гишүүн	ГССҮТ-ийн поликлиникийн эрхлэгч	АШУ-ны магистр, Клиникийн профессор
11	Б.Батзориг	Гишүүн	ГССҮТ-ийн поликлиникийн эрхлэгч	АШУ-ны магистр, Клиникийн профессор
14. Цус судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Н.Оюундэлгэр	Ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны докторант, Клиникийн профессор
2	Т.Алимаа	Нарийн бичгийн дарга	ЦССҮТ-ийн их эмч	АУ-ны магистр, Зөвлөх зэргийн эмч
3	Ц.Одгэрэл	Гишүүн	АШУҮИС-ийн АУС-ийн Цусны эмгэг судлалын тэнхмийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
4	Г.Чимгээ	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Цусны клиникийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
5	Т.Болормаа	Гишүүн	УНТЭ-ийн Чанар, дотоод хяналтын албаны дарга	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч
6	Б.Хишигжаргал	Гишүүн	УГТЭ-ийн Цусны клиникийн эмч	Анагаах ухааны магистр
7	Н.Халиун	Гишүүн	ЦССҮТ-ийн их эмч	АУ-ны магистр
15.Сэргээн засах тусламжийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	О.Батгэрэл	Ерөнхий мэргэжилтэн	УГТЭ-ийн Эрдэм шинжилгээ, сургалт, хамтын ажиллагаа хариуцсан орлогч дарга	Анагаах ухааны доктор
2	Х.Ариунаа	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Хөдөлгөөн заслын тэнхмийн багш	Анагаах ухааны магистр

3	А.Балжинням	Гишүүн	АШУҮИС-ийн Гэмтэл согог сэргээн засахын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
4	Д.Цагаан	Гишүүн	Ачтан эмнэлгийн Сэргээн засах эмнэлгийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор
5	Ц.Цэнгэлмаа	Гишүүн	ХСҮТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
6	Ш.Цэцэгсанаа	Гишүүн	ГССҮТ-ийн Сэргээн засах тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
7	О.Амаржаргал	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн ЭБЭЭ-ийн сэргээн засах тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
8	Г.Туяа	Гишүүн	Рашаан судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч
9	Г.Ганцэцэг	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн Сэргээн засах тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
16. Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Г.Ариунтуул	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС, Нүүр ам судлалын сургуулийн захирал	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Б.Оюунцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
3	Л.Хэнтий	Гишүүн	АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургуулийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
4	Б.Дорж	Гишүүн	Хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, дэд профессор
5	Г.Аянга	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
6	Л.Даваанням	Гишүүн	АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургуулийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
7	Оюун	Гишүүн	"Перфект" эмнэлгийн захирал	Анагаах ухааны доктор
8	Н.Пүрэвжав	Гишүүн	АШУҮИС, Нүүр ам судлалын сургуулийн багш	Анагаах ухааны доктор, профессор
9	Цэрэндулам	Гишүүн	Хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
10	Амаржаргал	Гишүүн	Хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
11	М.Энхтайван	Гишүүн	Монголын нүүр амны сувилахуйн нийгэмлэгийн тэргүүн	Анагаах ухааны магистр, докторант
17. Мэдрэл судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Д.Өлзийбаяр	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
2	Л.Энхсайхан	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
3	А.Товуудорж	Гишүүн	АШУҮИС-ийн Мэдрэл	Анагаах ухааны доктор,

			судлалын тэнхмийн эрхлэгч	дэд профессор
4	Л.Отгонбаяр	Гишүүн	АШУҮИС-ийн Мэдрэл судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор, дэд профессор
5	Ц.Ганзориг	Гишүүн	УХТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
6	П.Алтанцэцэг	Гишүүнч	"УГТЭ-ийн Мэдрэлийн төвийн дарга	Тэргүүлэх зэргийн эмч
7	С.Дариймаа	Гишүүн	УГТЭ-ийн Мэдрэлийн тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
8	О.Энхчимэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Мэдрэл судлалын тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
9	Ж.Сарангэрэл	Гишүүн	" Рефлекс" эмнэлгийн захирал	Анагаах ухааны доктор
10	Ж.Ариунаа	Гишүүн	УГТЭ-ийн Харвалтын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр Тэргүүлэх зэргийн эмч
11	Н.Лхамцоо	Гишүүн	УГТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн их эмч	Анагаах ухааны доктор
18. Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	Б.Энхжаргал	Ерөнхий мэргэжилтэн	ШУТИС -ийн ЭХИС-ийн багш	ТУ-ны доктор, профессор, МУ-ын эмнэлгийн техникийн зөвлөх инженер
2	Р.Даваасүрэн	Нарийн бичгийн дарга	ЭХЭМҮТөв –ийн Эмнэлгийн техникийн албаны инженер	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
3	Ж.Ганбат	Гишүүн	УНТЭ–ийн Эмнэлгийн техникийн албаны инженер	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшсэн инженер
4	Б.Баасанхүү	Гишүүн	Монголын эмнэлгийн инженерүүдийн нийгэмлэгийн гишүүн	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
5	Ж.Баярмаа	Гишүүн	МХЕГ-ын улсын ахлах байцаагч	Физикийн ухааны доктор, физикч
6	Б.Батцэнгэл	Гишүүн	ЭМХТ-МТЭТТА –ны мэргэжилтэн	ТУ-ны магистр, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
7	Н.Мэнджаргал	Гишүүн	Монголын эмнэлгийн инженерүүдийн нийгэмлэгийн гишүүн	ТУ-ны магистр, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшсэн инженер
19. Чих, хамар, хоолойн мэргэжлийн салбар зөвлөл				
1	Э.Жаргалхүү	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Чих хамар, хоолойн эмгэг судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
2	М.Заяа	Нарийн бичгийн дарга	"Ач" АУИС-ийн Чих хамар хоолойн тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
3	Б.Эрдэнэчулуун	Гишүүн	АШУҮИС-ийн Чих хамар, хоолойн эмгэг судлалын тэнхмийн зөвлөх	АШУ-ныдоктор, профессор
4	Л.Бямбасүрэн	Гишүүн	Монголын чих, хамар,	Анагаах ухааны доктор

			хоолойн эмч нарын нийгэмлэгийн тэргүүн	
5	Б.Дэлгэрмаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
6	Д.Арьяамаа	Гишүүн	УНТЭ-ийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
7	Д.Чулуунбаатар	Гишүүн	УХТЭ-ийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
8	С.Бямбасүрэн	Гишүүн	УГТЭ-ийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгч	Анагаах ухаанымагистр, Тэргүүлэх зэргийн эмч
9	М.Сонинжаргал	Гишүүн	СХДЭМТ-ийн Чих хамар хоолойн эмч	Ахлах зэргийн эмч
20. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	Ц.Содномпил	Ерөнхий мэргэжилтэн	АХБ-ны төслийн зөвлөх	Анагаах ухааны доктор
2	Д.Нарансүх	Нарийн бичгийн дарга	АШҮҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш	НЭМШУ-ны магистр, НЭМ-ийн магистр
3	О.Чимэдсүрэн	Гишүүн	АШҮҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал	Анагаах ухааны доктор, профессор
4	Ш.Оюунбилэг	Гишүүн	НҮБ-ын Хүүхдийн сангийн зөвлөх	Анагаах ухааны доктор
5	Ж.Наранчимэг	Гишүүн	НЭММН-ийн гишүүн	НЭМ-ийн магистр
6	Э.Эрдэнэчимэг	Гишүүн	АШҮҮИС, НЭМС-ийн Орчны эрүүл мэндийн тэнхмийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
7	И.Болормаа	Гишүүн	НЭМХ-ийн ЭША	Анагаах ухааны доктор
8	Н.Наранбат	Гишүүн	"Гялс" төвийн захирал	Анагаах ухааны доктор
9	Л.Гэрэлмаа	Гишүүн	МХЕГ-ын улсын байцаагч, хэлтсийн дарга	НЭМ-ийн магистр
21. Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Д.Энхжаргал	Ерөнхий мэргэжилтэн	АШҮҮИС-ийн Эм зүйн сургуулийн захирал	Эм зүйн ухааны доктор, профессор
2	Х.Дариймаа	Нарийн бичгийн дарга	АШҮҮИС-ийнЭм зүй, био анагаахын сургуулийн Эмийн хими, ургамал судлал, технологийн тэнхмийн багш	ЭЗУ-ны доктор
3	Д. Дүнгэрдорж	Гишүүн	АШҮҮИС-ийн зөвлөх	Академич, ЭЗШУ доктор, профессор,
4	Л. Хүрэлбаатар	Гишүүн	Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн удирдах зөвлөлийн дарга	Академич, ЭЗУ-ны доктор, профессор
5	Г. Чойжамц	Гишүүн	Оточ Манрамба Дэд сургуулийн захирал	Анагаах ухааны доктор, профессор
6	Ц.Даваасүрэн	Гишүүн	АШҮҮИС, Эмийн хими, ургамал судлал, технологийн тэнхмийн багш	ЭЗУ-ны доктор, дэд профессор

7	С. Мөнхбат	Гишүүн	АШУҮИС, Эмнэлзүйн эм зүй, зохион байгуулалтын тэнхмийн багш	ЭЗУ-ны доктор
8	О. Уранчимэг	Гишүүн	ХСҮТ, Эм зүйн албаны дарга	ЭЗУ-ны доктор
9	Ч. Ерөөлт	Гишүүн	АШУҮИС, Эм зүй, био анагаахын сургуулийн Эм судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
10	Д.Цэндээхүү	Гишүүн	Монголын эм хангамжийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч	ЭЗШУ-ны доктор, профессор
11	Р.Мөнхцэцэг	Гишүүн	Эм холбооны гишүүн, Цомбо ХХК захирал	ЭЗУ-ны доктор
22. Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл				
1	Н. Наранбаатар	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн захирал	Анагаах ухааны доктор
2	Б.Төмөрчөдөр	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн Сувилахуйн сургалт хариуцсан мэргэжилтэн	Сувилахуйн ухааны магистр, докторант
3	С.Оюунцэцэг	Гишүүн	АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын албаны дарга	Сувилахуйн ухааны доктор
4	О.Казил	Гишүүн	Улаанбаатар их сургуулийн сувилахуйн сургуулийн захирал	Сувилахуйн ухааны доктор, профессор
5	Г.Ганхуяг	Гишүүн	Орхон аймгийн "MEDIPAS" төв эмнэлгийн сувилахуйн албаны дарга	Сувилахуйн ухааны доктор
6	Я.Энхжаргал	Гишүүн	АШУИС-ийн сувилахуйн сургуулийн НЭМ-ийн тэнхмийн эрхлэгч	Сувилахуйн ухааны доктор
7	Д.Пүрэвдаваа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Сувилахуйн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
8	С.Дуламсүрэн	Гишүүн	ХСҮТ-ийн Сувилахуйн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
9	Д.Нямсүрэн	Гишүүн	УХТЭ-ийн сувилахуйн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
10	Л.Хишигдэлгэр	Гишүүн	Сувилахуйн сургуулийн эх хүүхдийн тэнхмийн багш	Сувилахуйн ухааны магистр, докторант
11	Д.Отгонцэцэг	Гишүүн	АШУҮИС-ийн сувилахуйн багш	Сувилахуйн ухааны магистр
23. Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Ш.Энхтуяа	Ерөнхий мэргэжилтэн	ЭСҮТ-ийн зөвлөх	Анагаах ухааны доктор
2	Э.Баярмаа	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Эм зүй, био анагаахынсургуулийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, профессор
3	Х.Гэрэлээ	Гишүүн	ОУЭС-ийн Монгол дахь хүрээлэнгийн тэргүүн	Анагаах ухааны доктор, дэд профессор

4	П.Дариймаа	Гишүүн	Эмгэг судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
5	Б.Туул	Гишүүн	АШУҮИС-ийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн ахлах багш	Анагаах ухааны магистр, Клиникийн профессор
6	Э.Ундармаа	Гишүүн	Эмгэг судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр, Клиникийн профессор,
7	Б.Уранчимэг	Гишүүн	Эмгэг судлалын үндэсний төвийн Чанарын менежер	Анагаах ухааны магистр, Клиникийн профессор
24. Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	О.Ганчулуун	Ерөнхий мэргэжилтэн	СЭМҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал	Клиникийн профессор, Зөвлөх зэргийн эмч
2	Н.Оюунчимэг	Нарийн бичгийн дарга	СЭМҮТ-ийн Чанарын албаны дарга	Анагаах ухааны магистр, докторант
3	Л.Эрдэнэбаяр	Гишүүн	СЭМҮТ-ийн зөвлөх эмч	Академич, АШУ-ны доктор, профессор
4	З.Хишигсүрэн	Гишүүн	АШУҮИС-ийн АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэнд судлалын тэнхмийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, дэд профессор
5	Т.Ганцэцэг	Гишүүн	АШУҮИС-ийн АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэнд судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч
6	И.Тунгалагтуяа	Гишүүн	СХД-ийн Эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмч	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч
7	Д.Лянхуа	Гишүүн	СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлаач эмч	Клиникийн профессор,тэргүүлэх зэргийн эмч
25. Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл				
1	С.Хишгээ	Ерөнхий мэргэжилтэн	ЭХЭМҮТ-ийн Эх барихын зөвлөх эмч	Анагаах ухааны доктор
2	Ц.Үржиндэлгэр	Нарийн бичгийн дарга	ЭХЭМҮТ-ийн нөхөн үржихүйн Зөвлөх поликлиникийн эрхлэгч	Боловсролын магистр, Тэргүүлэх зэргийн эмч
3	Г.Баттулга	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн захирал	Анагаах ухааны доктор
4	Т.Эрхэмбаатар	Гишүүн	АШУҮИС-ийн Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхмийн эрхлэгч	Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
5	Г.Мэндсайхан	Гишүүн	АШУҮИС-ийн Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
6	Д.Янжинсүрэн	Гишүүн	АШУҮИС-ийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
7	Д.Өнөржаргал	Гишүүн	"Өргөө" амаржих газрын Эмэгтэйчүүдийн тасгийн	Анагаах ухааны доктор

			эрхлэгч	
8	А.Отгонболд	Гишүүн	Хувийн эмнэлгийн холбооны дэд ерөнхийлөгч, Хатагтай эмнэлгийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч
9	Р.Хадбаатар	Гишүүн	Юнимед интернейшнл Эмнэлгийн үргүйдлийн клиникийн захирал	Анагаахын ухааны доктор, Клиникийн профессор
26. Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	С.Юндэн	Ерөнхий мэргэжилтэн	Хор судлалын төвийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор
2	Р.Даваадорж	Нарийн бичгийн дарга	НЭМХ-ийн Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа төвийн дарга	Анагаах ухааны магистр
3	С.Өнөрсайхан	Гишүүн	НЭМХ-ийн Хор, хордлого судлалын секторын эрхлэгч	Химийн ухааны доктор, дэд профессор
4	Ш.Паламдорж	Гишүүн	БХЭШХ-ийн ЭШ-ний тэргүүлэх ажилтан	ХШУ-ны доктор профессор
5	Ч.Гүрбазар	Гишүүн	Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн дарга	Анагаах ухааны магистр
6	В.Дэлгэрмаа	Гишүүн	ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн	Анагаах ухааны доктор, дэд профессор
7	Ш.Мөнхтулга	Гишүүн	ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн	Химийн ухааны магистр
8	Д.Сувд	Гишүүн	НЭМХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан	Биологийн ухааны доктор
9	Д.Баатарцол	Гишүүн	НЭМХ-ийн НЭМЛТ-ийн лабораторийн дарга	НЭМ-ийн магистр
27. Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Ж.Чинбүрэн	Ерөнхий мэргэжилтэн	ХСҮТ-ийн Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааныдоктор, профессор
2	М.Адилсайхан	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Хавдар судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
3	Г.Байгалмаа	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч	Анагаах ухааны магистр
4	Я.Эрдэнэ-Очир	Гишүүн	ХСҮТ-ийн Мэс заслын клиникийн удирдагч	Анагаах ухааныдоктор
5	Д.Авирмэд	Гишүүн	АШУҮИС-ийн Хавдар судлалын тэнхмийн багш, ХСҮТ-ийн зөвлөх эмч	Анагаах ухааны доктор
6	Р.Сандуйжав	Гишүүн	ХСҮТ-ийн мэс заслын зөвлөх	Анагаах ухааны доктор
7	Б.Ганзориг	Гишүүн	ХСҮТ-ийн Цээжний хөндийн мас заслын тасгийн эрхлэгч	

8	Г.Пүрэвдорж	Гишүүн	ХСҮТ-ийн Толгой хүзүүний мэс заслын тасгийн эрхлэгч	
9	М.Минжмаа	Гишүүн	ХСҮТ-ийн Туяа эмчилгээний их эмч	Анагаах ухааны доктор
28. Арьс гоо, заслын мэргэжлийн салбар зөвлөл				
1	Б.Хандсүрэн	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
2	Х. Алтанзул	Нарийн бичгийн дарга	"Гран-При" эмнэлгийн эмч	Анагаах ухааны доктор
3	Я.Энхтөр	Гишүүн	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор, профессор, Зөвлөх зэргийн эмч
4	М.Ариунаа	Гишүүн	АӨСҮТ-ийн лабораторийн эмч	Анагаах ухааны доктор
5	Ц.Уранчимэг	Гишүүн	АӨСҮТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал	Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
6	Д.Дэлгэрцэцэг	Гишүүн	БХХСАХНЭ-ийн ахлах эмч	Тэргүүлэх зэргийн эмч
7	Д.Оюун	Гишүүн	"Гранд мед" эмнэлгийн их эмч	Зөвлөх зэргийн эмч
29. Эрхтэн шилжүүлэх мэргэжлийн салбар зөвлөл				
1	О.Сэргэлэн	Ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Мэс заслын тэнхмийн эрхлэгч	АШУ-ны доктор, профессор, Зөвлөх зэргийн эмч
2	Б.Батсайхан	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Мэс заслын тэнхмийн багш	Анагаах ухааны доктор
3	Н.Туул	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч
4	Д.Баян-Өндөр	Гишүүн	УНТЭ-ийн БМЗТ-ийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, тэргүүлэх зэргийн эмч
5	Ж.Чинбүрэн	Гишүүн	ХСҮТ-ийн ЭЦНБ-н тасгийн эрхлэгч	Анагаах ухааны доктор, Тэргүүлэх зэргийн эмч
6	Л.Ганбаяр	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн хүүхдийн мэс заслын тасгийн эмч	Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
7	Б.Баттөгс	Гишүүн	ГССҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	Тэргүүлэх зэргийн эмч
8	С.Наранцэцэг	Гишүүн	УГТЭ- ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	Анагаах ухааны доктор, Тэргүүлэх зэргийн эмч
9	Б.Батсайхан	Гишүүн	УНТЭ-ийн ЭШСТ-ийн эмч	Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч
10	Д.Даваадорж	Гишүүн	АШУИС-ийн дэд захирал	Анагаах ухааны доктор, профессор
11	Б.Эрдэнэбилэг	Гишүүн	УНТЭ-ийн дүрс оношилгооны их эмч	Анагаах ухааны магистр

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 07 сарын 04 өдрийн
А/266 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

Мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэнд, спортын яамны ерөнхий мэргэжилтэн нь /цаашид ерөнхий мэргэжилтэн гэх/ эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тухайн мэргэжлийн чиглэлээр бодлогын төсөлд санал өгөх, удирдамж боловсруулах, цаг үеийн тулгамдсан асуудлаар яамны холбогдох газар, хэлтэстэй зөвшилцөн, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, хамтарч ажиллах чиг үүрэгтэй.

1.2. Ерөнхий мэргэжилтэн нь дор дурьдсан шалгуурыг хангасан байна. Үүнд:

- Тухайн мэргэжлийн чиглэлээр нэр хүндтэй, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн
- Анагаах ухааны доктор болон түүнээс дээш эзэрэг, цолтой
- Мэргэжлээрээ 10 буюу түүнээс дээш жил ажилласан
- Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй
- Ашиг сонирхолын зөрчилгүй
- Дахин томилох тохиолдолд үүрэгт хугацаандаа идэвхи, санаачлагатай ажиллаж байсан зэрэг болно.

1.3. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн чиглэлийн туршлага бүхий мэргэжлийн нийгэмлэг, холбоодын тэргүүн, холбогдох эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран ажиллана.

1.4. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөгяамны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй зөвшилцөн, эмнэлгийн тусламжийн хэлтсээр хянуулж, жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэнд, спортын сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.

1.5. Тухайн жилд хийсэн ажлын тайлангаа жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор багтаан холбогдох газар хэлтэст бичгээр өгч, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажлаа дүгнүүлнэ.

1.6. Ерөнхий мэргэжилтэн, мэргэжлийн салбар зөвлөл нь тогтсон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Ерөнхий мэргэжилтний ажлын чиг үүрэг

2.1. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдох мэргэжлийн чиглэлээр сүүлийн 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нийгэмлэг, холбоодын дарга, тэргүүн нарыг тухайн хэлэлцэх асуудалд шаардлагатай чиглэлээр албан ёсны гишүүний үүрэгтэйгээр татан оролцуулж санал авах, хэлэлцүүлэгт оролцуулах эрхтэй.

2.2. Яамны газар, хэлтэс, мэргэжилтнүүдтэй тухайн мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулна.

2.3 Ерөнхий мэргэжилтэн нь зохион байгуулахаар санаачилсан болон яам төлөөлсөн арга хэмжээнд оролцохдоо яамны холбогдох мэргэжилтнүүд, газар, хэлтэст урьдчилан танилцуулна.

2.4. Ерөнхий мэргэжилтэн нь яамны тухайн асуудлаарх бодлого, стратегийн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээнд хамтарч ажиллана.

2.5. Холбогдох үйл ажиллагааг яамны захиалгаар гүйцэтгэнэ.

2.6. Тухайн чиглэлээр салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар боловсруулсан баримт бичигт санал өгнө.

2.7. Мэргэжлийн чиглэлээр тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал, зөвлөмж өгөх, дүгнэлтэд оролцоно.

2.8. Мэргэжлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээ, сувилахуйн стандарт, эмнэл зүйн заавар удирдамж, сурах бичиг, гарын авлагыг боловсруулах, хянан тохиолдуулахад оролцоно.

2.9. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сайжруулах, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн өвөрмөц хэм хэмжээг боловсруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг мөрдүүлэх талаар санаачлагатай ажиллана.

2.10. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн боловсролын стандарт боловсруулах, мэргэжлийн индексийг боловсронгуй болгоход оролцоно.

2.11. Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, санал өгнө.

2.12. Тухайн мэргэжлийн чиглэлээр яаманд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд оролцох, санал өгөх, газар дээр нь очиж хянаж үнэлэх, дүгнэлт гаргахад оролцоно.

Гурав. Мэргэжлийн салбар зөвлөлийн ажлын чиг, үүрэг

3.1. Мэргэжлийн салбар зөвлөл / цаашид зөвлөл гэх / нь ерөнхий мэргэжилтний үйл ажиллагааг дэмжин ажиллах ба яамнаас гаргах бодлого, явуулах үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг өгч хамтран ажиллах үүрэгтэй.

3.2. Зөвлөл нь тухайн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, нийгэмлэг, холбоодын тэргүүн, эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7-11 хүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэнд, спортын сайд баталгаажуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Гишүүдийн олонхи буюу 75 хувийн ирцтэй тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.

3.4. Зөвлөл нь сард 1 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаж болно.

3.5. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа шийдвэр гаргана. Шийдвэр нь тухайн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна. Шийдвэрийг ерөнхий мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчинтэйд тооцож, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.6. Зөвлөл нь тухайн мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд, бодлого боловсруулагчдад анагаах ухааны техник-технологийн дэвшлийг нэвтрүүлэх талаар санал, зөвлөмж өгч, мэдээллээр хангаж ажиллана.

3.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулж буй бусад холбогдох байгууллагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

3.8. Холбогдох асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг судлан мэргэжлийн санал, дүгнэлт гаргана.

3.9. Гадаад, дотоодын бусад мэргэжлийн нийгэмлэг, холбоод, ТББ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллана.

3.10. Улс оронд аюул, гамшгийн байдал тохиолдоход мэргэжлийн чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтэнд биечлэн оролцоно.

3.11. Зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна.

3.12. Нарийн бичгийн дарга нь:

- Ерөнхий мэргэжилтний зааварчилгаагаар салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан бичгийг боловсруулах,
- Зөвлөлийн хурал зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх, хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлтгэх,
- Ерөнхий мэргэжилтний шийдвэрээр гишүүдэд урамшуулал болон батлагдсан төсвийн гүйцэтгэлийг олгох ажлыг гүйцэтгэх,
- Зардлын тооцоог Эрүүл мэнд, спортын яамны ерөнхий нягтлан бодогчид хүлээлгэж өгөх,
- Мэргэжлийн салбар зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, хурлын тэмдэглэл, санал, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох зааврын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж яамны архивт шилжүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

3.13. Зөвлөлийн гишүүд нь хуралд санал өгөх эрхтэй оролцох, мэргэжлийн зөвлөлийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ санаа, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хэрэгжилтэд биечлэн оролцох, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааг уялдуулах, гадаад дотоодын нийгэмлэг, холбоодын туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх, холбогдох шийдвэр гаргахад Эрүүл мэнд, спортын яамтай хамтран ажиллана.

3.14. Зөвлөл нь ашгийн төлөө ямар нэг үйл ажиллагаа явуулахгүй, зохион байгуулахгүй.